



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/13

Хөхбүрд

Ерөнхий боловсролын сургуулийн заалны барилгын их засварын ажилд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Ерөнхий боловсролын сургуулийн заалны барилгын их засвар"-ын ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулсугай.

2. Хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ганцоож (Засаг даргын Орлогч)

Гишүүд: Д.Отгонцэцэг (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Мөнх-Эрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

У.Гантулга (Биеийн тамирын арга зүйч)

Ц.Отгонбат (Биеийн тамирын багш)

М.Ганбаатар (Байгаль хамгаалагч)

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд "Ерөнхий боловсролын сургуулийн заалны барилгын их засвар"-ын ажлыг нэг бүрчлэн хариуцлагатай чанартай гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт хийж, ажлын талаарх шаардлагатай тэмдэглэл, фото зургийг тухай бүр нь баримтжуулан илтгэх хуудасны тайлагнахыг ажлын хэсэгт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОРХОНТУУЛ



642301149